# ОРХОН АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Т. Байгалмаа
Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах
Одхүү 2021.5.21

2021 оны 05 сарын 19 өдөр    Дугаар А/280    Эрдэнэт

Нэмэлт амин дэмээр хангахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.1.5/а/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийн 3.2.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит II хуралдааны 02/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт амин дэмээр хангахад дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 5,000,000 (Таван сая ) төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлын (Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг амин дэмжүүлэх, цус цусан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах) зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ) -т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА    С.БАТЖАРГАЛ

D:(Zahiramj) A-4 doc
61?1021?49

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 19-ын өдрийн
А/280 дугаар захирамжийн хавсралт

**НИЙГМИЙН ХАЛАМЖ НЭН ШААРДЛАГАТАЙ БҮЛГИЙН ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ЭХЧҮҮДИЙГ НЭМЭЛТ АМИН ДЭМЭЭР ХАНГАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

| Жилээр | Эмийн нэр | 1 эхэд олгох тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | 1 эхэд оногдох төсөв | Хамрагдах эхийн тоо | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|
| III-IV улирал | Ферровит | 30 ширхэг | 17,400 | 580 | 287 | 5.000.000 |

**НИЙГМИЙН ХАЛАМЖ НЭН ШААРДЛАГАТАЙ ЭХЧҮҮДЭД ТҮГЭЭХ АМИНДЭМИЙН ХУВААРИЛАЛТ**

| № | СӨЭМТ-үүдийн нэр | Жирэмсэн эхийн тоо | Аминдэм олгох жирэмсэн эхийн тоо | 1 эхэд оногдох төсөв /төг/ | Бүгд |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мэндцэцэн | 258 | 45 | 17,400 | 783,000 |
| 2 | Анхны оч | 255 | 45 | 17,400 | 783,000 |
| 3 | Учралтбаяр | 202 | 35 | 17,400 | 609,000 |
| 4 | Энхжих мандарваа | 208 | 35 | 17,400 | 609,000 |
| 5 | Үйлсбадрах | 210 | 32 | 17,400 | 556,800 |
| 6 | Мөнхийн гэгээ | 190 | 26 | 17,400 | 452,400 |
| 7 | Нийцэл | 193 | 26 | 17,400 | 452,400 |
| 8 | Мөнхсүндрэл | 136 | 26 | 17,400 | 452,400 |
| 9 | Жаргалант сум | 42 | 17 | 17,400 | 295,800 |
| Дүн | | 1694 | 287 | | 5,000,000 |

_ОО_